



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 95

Ховд

Г Хөрөнгө оруулалтын талаар

авах зарим арга хэмжээний
тухай

Сумдад хийгдэж буй хөрөнгө оруулалтын үр дүн, цаашдын зорилтын тухай Дөргөн сумын Засаг дарга Т.Заяа, Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд Хурлын байгууллагаас хяналтыг хэрэгжүүлэн, иргэдийн оролцоог ханган ажиллаж буй тухай Дөргөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Базаррагчаа нарын илтгэл, Буянт, Мянгад сумдын мэдээллийг ХЭЛЭЛЦЭЭД:

Хөрөнгө оруулалтын ажлын чанар, хэрэгжилтийн явц үр дүнг сайжруулах иргэд олон нийтийн хөндлөнгийн хяналтын системийг бий болгож тогтмолжуулах, Төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, удирдлага зохион байгуултаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх, тайлagnaх, үр ашгийг нэмэгдүүлэх санал боловсруулж хэрэгжүүлэх, улс, аймаг, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусlamж бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний зураг төсөв норм дүрмийн дагуу хийгдээгүйн улмаас ажлын явцад нөлөөлж удаашрах, хугацаа алдах, зураг төсөвт өөрчлөлт оруулах байдал байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнд муугаар нөлөөлж болзошгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.3, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Ус” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх журам” –ын 2 дугаар бүлгийн 2.1, 2.2.3, 3 дугаар

бүлгийн 3.2 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Аймаг, сумдын Засаг дарга нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө, иргэд олон нийтийн санал авч эрэмбэлэх асуудлыг үр дүнд хүргэж, аймаг сумдын хөгжлийн бодлоготой уялдуулах, ажлын тоо хэмжээ, даалгавар, зураг төсвийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гаргуулан баталгаажуулсны дараа Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих, бүртгэх, тайлاغнах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг сайжруулах

2.Улс, аймаг, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний Худалдан авах ажиллагааг /тендер/ оны эхнээс төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих

3.Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр шинээр барьж байгуулах, засварлах объектуудад орон нутгийн хяналтыг, гүйцэтгэх ажлын явцад Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газрын хяналт, иргэдийн хөндлөнгийн хяналтыг эрс сайжруулж ашиглалтад хүлээн авах комиссын хариуцлагыг дээшлүүлэх, өмнө нь гаргасан алдаа, дутагдал, доголдлыг арилгуулах арга хэмжээ авах, зураг төсөв, гүйцэтгэж дуусах хугацаа, гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, хаяг, холбоо барих утас зэрэг мэдээллийг ил тод самбарт байрлуулан олон нийтэд сурталчилж ажиллах

4.Буянт, Ховд, Дуут сумдын хилийн цэс газар нутгийн маргааны асуудлыг шийдвэрлэх, Дөргөн сумын үндны болон бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээ муу бохирдол ихтэй, бэлчээрийн даац 3-5 дахин хэтрэлттэй, нутаг дэвсгэрийн 90-99 хувь цөлжилттэй, нуурын усны түвшин нэмэгдэж, бохирдол ихсэж намагшил явагдаж байгаа зэрэгт мэргэжлийн байгууллагуудаар судалгаа шинжилгээ хийлгэж үнэлэлт дүгнэлт өгч, бодлого хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх.

5.Дөргөний Усан цахилгаан станцаас аймгийн төсөвт төвлөрүүлж буй ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 40 - өөс доошгүй хувийг байгаль орчны нөхөн сэргээлт, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан үндны цэвэр усаар хангах үйл ажиллагаанд зориулж хязгаарлалтын бүсэд хамаарах Дөргөн суманд жил бүр олгож байх

Хоёр. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хар нуур, Ховд голын сав газрын захиргааны дарга нарт ҮҮРЭГ БОЛГОХ нь:

1.Улс, аймаг, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэлийн хяналт тавих

2.Захиалагчийн хяналтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах, шинэ барилга байгууламж болон их засварын ажлын техникийн бичиг баримт, ажлын гүйцэтгэл, санхүүгийн бичиг баримтын бүрдлийг шалган заавар өгч, хянаж баталгаажуулах

3.Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ил, далд ажлын актыг баталгаажуулах, материалын стандартыг хангуулах, гүйцэтгэлийг хянаж батлах, санхүүжүүлэх, шаардлага хангасан объектыг ашиглалтад оруулж байх

4.Буянт, Ховд, Дуут сумдын хилийн цэс, газар нутгийн маргааны асуудлыг шийдвэрлэх, Дөргөн сумын үндны болон бэлчээрийн усан хангамжийн хүрэлцээ муу


бохирдол ихтэй бэлчээрийн даац 3-5 дахин хэтрэлттэй, тус сумын нутаг дэвсгэр 90-99 хувийн цөлжилттэй, нуурын усны түвшин нэмэгдэж бохирдол ихсэж намагшил явагдаж байгаа зэрэгт судалгаа шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч бодлого хөтөлбөр боловсруулан жил бүрийн төсөвт суулган хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Гурав. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт ЗӨВЛӨХ нь:

1.Төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө иргэд олон нийтийн санал авч эрэмбэлсэн байх, аймаг сумдын хөгжлийн бодлоготой уялдуулах, ажлын тоо хэмжээ, даалгавар, зураг төсвийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гаргуулан баталгаажуулах

2.Сум орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлын явц, гүйцэтгэл, чанар байдал, үр дүнг сайжруулах, мэргэжлийн хүмүүс, иргэд олон нийтээс бүрдсэн ажлын хэсэг, хяналтын зөвлөлийг тогтмол ажиллуулж, тайлан мэдээг холбогдох байгууллага болон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж байх

Дөрөв. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 96

Ховд

Ардчилсан хувьсгалын 30 жилийн
оий тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ардчилсан хувьсгалын 30 жилийн оиг Монгол орон даяар тэмдэглэн өнгөрүүлж байгаатай холбогдуулан Ардчиллын ололт амжилт, үнэт зүйл, түүхэн үйл явцыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ардчилсан хувьсгалын 30 жилийн оиг 2019 оны 12 дугаар сарын 07 –ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Ардчилсан хувьсгалын 30 жилийн оиг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн

ахлагч: Ч.Чинбат - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгч, Ардчилсан намын дарга

Гишүүд: Д.Батхуяг - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгч, Тэргүүлэгч

Л.Энхбаяр - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгч, Тэргүүлэгч

Б.Банзрагч - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгч

Д.Энхболд - Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын дарга

Ч.Багдал - Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга: О.Очирбат - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын
албаны Олон нийт, иргэдтэй харилцах хэлтсийн
мэргэжилтэн

0000278

3. Ардчилсан хувьсгалын 30 жилийн ойг Ховд аймагт тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 97

Ховд

Үндсэн хөрөнгө худалдан авах
зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3, 77.4 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 85 дугаар тушаал, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд суудлын авто машин худалдан авахад зориулан 69000000 /жаран есөн сая/ төгрөгөөр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралтын ажлын барилгын захиалагчийн техник хяналтын зардлаас зарцуулах эрхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

2.Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт худалдан авах суудлын авто машины техникийн тодорхойлолтыг 69000000 /жаран есөн сая/ төгрөгөөр тооцож хавсралтаар баталсугай.


3.Хөрөнгө худалдаж авах нээлттэй тендер зохион байгуулж, хөрөнгийг нягтлан бodoх бүртгэлийн хуулийн дагуу данс бүртгэлд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, ашиглалтыг хариуцаж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ

0000288

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 97 дугаар
тогтоолын хавсралт



ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр | Үйлдвэрлэсэн | | Үзүүлэлт, марк | Худалдан авах дүн | | |
|---|--------------------------|--------------|------|------------------|-------------------|-------------|-----------|
| | | улс | он | | тоо | Нэгжийн үнэ | Үнийн дүн |
| 1 | Prado суудлын авто машин | Япон | 2013 | Toyota Prado 150 | 1 | 69000000 | 69000000 |
| | Дүн | | | | 1 | 69000000 | 69000000 |

---00---



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 98

Ховд

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Хуралдаан зарлах тухай” 94 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэлэлцэх асуудлын жагсаалтад дараах нэмэлт өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1. Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай

Илтгэгч нь: Аймгийн Сонгуулийн хорооны дарга Л.Батбаяр

1.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай

Илтгэгч нь: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Пүрэвганди

1.3. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны зорилтын тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.4. Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны батлагдсан төсвийн хэрэгжилт, 2020 оны төсвийн төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.5. Аймгийн 2020 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар аймгийн Аудитын газраас өгөх саналын тухай

0000290

Илтгэгч нь: Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар

1.6.Аймгийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний биелэлт,
2020 оны төлөвлөгөөний төслийн тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.7.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай” 8/10 дугаар тогтоол, “Ховд аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрөл олгох, гүйцэтгэх журам батлах тухай 8/08 дугаар тогтооцуудыг хүчингүй болгох тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг

1.8.Орон нутгийн татварын хувь хэмжээ тогтоох тухай.

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.9.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Илтгэгч нь: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
дахь Монгол ардын намын бүлгийн
дарга М.Ганзориг





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 99

Ховд

Г Хөрөнгө бүртгэлээс хасах санал
уламжлах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,2,3 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Ланд круизер-200 маркийн, 110,000,000 төгрөг /нэг зуун арван сая/-ийн балансын үнэтэй, 108,472,222 төгрөг /нэг зуун найман сая дөрвөн зуун далан хоёр мянга хоёр зуун хорин хоёр/-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас хасаж, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын балансад бүртгүүлэх саналыг дэмжин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжилсугай.

2.Хөрөнгө бүртгэлийн давхардлыг арилгах асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/, Орон нутгийн өмчийн гарын дарга /Ш.Нохойжав/ нарт үүрэг болгосугай.



0000293



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 100

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Гавьяат механикуулагч”- аар

- | | |
|------------------|--|
| 1. Дэндэв Батсүх | - Ховд аймгийн Үенч сум, Хөх үзүүр багийн өндөр настан |
|------------------|--|

“Худалдааны гавьяат ажилтан”- аар

- | | |
|----------------------|---|
| 2. Самдан Агчинсүрэн | - Ховд аймгийн Жаргалант сум, Бугат багийн өндөр настан |
|----------------------|---|

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

- | | |
|------------------------|--|
| 1. Лхаасүрэн Баарай | - Жаргалант сум, Тахилт багийн иргэн |
| 2. Аюурзана Цагаач | - Мянгад сумын Ахмадын хорооны дарга |
| 3. Хумаажаа Бат-Эрдэнэ | - Монголын өв соёл холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч |

0000292

“Алтангадас одон”- гоор

- | | |
|----------------------------|--|
| 1. Пунсанхорлоо Мөнхбат | - Манхан сумын Засаг дарга, Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч |
| 2. Буяндалай Амгаланбадрах | - Булган сумын Засаг дарга Аймгийн ИТХ-ын Төлөөлөөч |
| 3. Баядбаатар Нацаг | - Жаргалант сумын Буянт багийн иргэн, “Алтайн замын жигүүр” холбооны тэргүүн |
| 4. Хандсүрэн Батчулуун | - Жаргалант сумын Хайрхан багийн иргэн |

“Хөдөлмөрийн хүндэт медаль” - иар

- | | |
|-----------------------------|--|
| 1. Жигжидсүрэн Нямсүрэн | - Хөшөөтийн уурхайн хүнд механизмын жолооч |
| 2. Көпес Аманбай | - Ховд сумын Баянбулаг багийн малчин |
| 3. Даваажав Ганзориг | - Чандмань сумын ЗДТГ-ын дарга |
| 4. Төмөрчөдөр Батхуяг | - Булган сумын ИТХ-ын дарга |
| 5. Жалаа Занданхүү | - Дуут сумын ЗДТГ-ын мэргэжилтэн |
| 6. Дэвээ Дарьсүрэн | - Жаргалант сумын Баатархайрхан багийн өндөр настан |
| 7. Ханд Гэрэл | - Жаргалант сумын Баатархайран багийн өндөр настан |
| 8. Далай Гантоого | - Ховд аймгийн БОЭТ-ийн асралч, үйлчлэгч |
| 9. Самбуу Очирсүрэн | - Жаргалант сумын Баатархайрхан багийн өндөр настан |
| 10. Жамхий Долгор | - Жаргалант сумын Бичигт багийн өндөр настан |
| 11. Жигдсүрэн Баттулга | - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн өндөр настан |
| 12. Жанагаа Батжаргал | - Жаргалан сумын Буянт багийн өндөр настан |
| 13. Сүрэн Лхагвасүрэн | - МХС ТӨХК-ний Ховд аймгийн газрын дарга, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч |
| 14. Цэлээжав Нямдагва | - Жаргалант сумын Хайрхан багийн өндөр настан |
| 15. Лхагвацэрэн Бадамхорлоо | - БОЭТ-ийн Амбулаторийн тасгийн эрхлэгч ЭМЧ |

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 101

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Мал угаалгын ванн, мал хаших хашаа барих ажлын хавсралтад тусгагдсан 15961835 төгрөг /арван таван сая есөн зуун жаран нэгэн мянга найман зуун гучин тав/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Мянгад, Дөргөн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн ашиглалтыг хариуцаж ажиллахыг Мянгад, Дөргөн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ

0000325

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны
12. сарын 18.-ны өдрийн 101 дугаар
тогтоолын хавсралт

**МЯНГАД, ДӨРГӨН СҮМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

/төгрөг/

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ |
|--|--|-------------------------|----------------------|---------------|-------------------|---|
| Мянгад суманд хийгдсэн мал угаалгын ванн, хашаа | | | | | | |
| 1 | Мал угаалгын ванн /урт-5м, өргөн-1.5м, гүн-1.5м, ус баригч- 3м/ | 2019 | ш | 1 | 5,100,000 | 5,100,000 |
| 2 | Мал хা�ших зөөврийн хашаа /өндөр-1.2м, урт-1.8м | 2019 | иж бүрдэл- 61ш | 1 | 2,852,629 | 2,852,629 |
| ДҮН | | | | | | 7,952,629 |
| Дөргөн суманд хийгдсэн мал угаалгын ванн, хашаа | | | | | | |
| 1 | Мал угаалгын ванн /урт-5м, өргөн-1.5м, гүн-1.5м, ус баригч- 3м/ | 2019 | ш | 1 | 5,000,000 | 5,000,000 |
| 2 | Мал хা�ших зөөврийн хашаа /өндөр-1.2м, урт-1.8м | 2019 | иж бүрдэл- 61ш | 1 | 3,009,206 | 3,009,206 |
| ДҮН | | | | | | 8,009,206 |
| НИЙТ ДҮН | | | | | | 15,961,835 |
| | | | | | | /арван таван сая есэн зуун жаран нэгэн мянга найман зуун гучин тав/ |

.....ооо.....



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 102

Ховд

Г

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийлүүлэгдсэн хог хаягдал зайлцуулах, булах универсал авто ачигч нийлүүлэх ажлын 79900000 төгрөг /далан есөн сая есөн зуун мянга/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Баттогтох/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн ашиглалтыг хариуцаж ажиллахыг Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ

0000308



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 103

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн аймгийн 16 сумын Хүүхдийн цэцэрлэгт гэр нийлүүлэх ажлын хавсралтад тусгагдсан 29050000 төгрөг /хорин есөн сая тавин мянга/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Алтай, Булган сумын 2-р цэцэрлэг, Буянт, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Манхан, Мянгад, Мөст, Мөнххайрхан, Ховд, Цэцэг, Чандмань, Үенч, Эрдэнэбүрэн сумдын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн ашиглалтыг хариуцаж ажиллахыг дээрх сумдын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПУРЭВГАНДИ

0000310

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны
103 дугаар тогтоолын хавсралт

АЛТАЙ, БУЛГАН СУМЫН 2-Р ЦЭЦЭРЛЭГ, БУЯНТ, ДАРВИ, ДӨРГӨН, ДУУТ, ЗЭРЭГ,
МАНХАН, МЯНГАД, МӨСТ, МӨНХХАЙРХАН, ХОВД, ЦЭЦЭГ, ЧАНДМАНЬ, ҮЕНЧ,
ЭРДЭНЭБҮРЭН СУМДЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөг/

| Д/д | Хөрөнгийн нэр, төрөл | Ашиглалта нд орсон он | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ |
|-----|---|-----------------------------|--------------------|---------------|---|--|
| 1 | Тооно | 2019 | ширхэг | 16 | 195,000 | 3,120,000 |
| 2 | Багана | 2019 | хос | 16 | 95,000 | 1,520,000 |
| 3 | Хаалга | 2019 | ширхэг | 16 | 190,000 | 3,040,000 |
| 4 | Унь | 2019 | 1 гэр багц | 16 | 290,000 | 4,640,000 |
| 5 | Хана | 2019 | 1 гэр багц /5ш/ | 16 | 280,000 | 4,480,000 |
| 6 | Дээвэр | 2019 | 2 гэр багц /2ш/ | 16 | 130,000 | 2,080,000 |
| 7 | Туурга | 2019 | 3 гэр багц /4ш/ | 16 | 155,000 | 2,480,000 |
| 8 | Өрх | 2019 | ширхэг | 16 | 40,000 | 640,000 |
| 9 | Берзинтэн бүрээс | 2019 | ширхэг | 16 | 130,000 | 2,080,000 |
| 10 | Гадна цагаан бүрээс | 2019 | ширхэг | 16 | 90,000 | 1,440,000 |
| 11 | Дотор цагаан бүрээс /цаваг/ | 2019 | ширхэг | 16 | 40,000 | 640,000 |
| 12 | Дотуур хөшиг | 2019 | 1 гэр багц | 16 | 45,000 | 720,000 |
| 13 | Гялгар цаас | 2019 | ширхэг | 16 | 30,625 | 490,000 |
| 14 | Гэрийн бүс | 2019 | 1 гэр багц | 16 | 30,000 | 480,000 |
| 15 | Дотуур бүс | 2019 | 1 гэр багц | 16 | 20,000 | 320,000 |
| 16 | Өрхний оосор | 2019 | 1 гэр багц | 16 | 15,000 | 240,000 |
| 17 | Туурга, дээвэр, тооно, өрх, ханын уяа | 2019 | 1 гэр багц | 16 | 30,000 | 480,000 |
| 18 | Хөшигний уяа | 2019 | 1 гэр багц | 16 | 10,000 | 160,000 |
| ДҮН | | | | | 1,815,625 | 29,050,000 |
| | | | | 16 | 1,815,625 /нэг сая найман зуун арван таван мянга зургаан зуун хорин тав/ | 29,050,000 /хорин есэн сая тавин мянга/ |